

## ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

### **Б.Гомбосүрэн**

ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, докторант, хурандаа

***Товч агуулга:** Хилийн боомт дахь хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам*

***Түлхүүр үгс:** хилийн, хяналтын байгууллагууд, хамтын ажиллагаа, уялдаа холбоо.*

**Оршил.** Шинжлэх ухааны ололтод тулгуурласан, нэвтрүүлэх хүчин чадал өндөртэй дэд бүтцийг хилийн боомтуудад бүрдүүлж олон улсын жишигт хүргэх, хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомтуудад түшиглэн хөгжих чиг хандлагыг бий болгох, экспорт, импортын хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, хилийн хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Үндсэн хэсэг. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих явцад хилийн хяналтын байгууллагууд нь зохион байгуулалт, ашиг сонирхол, харьяалал, үйл ажиллагааны зорилго ба чиглэл, хуулийн өмнө хүлээх хариуцлага, өмчлөлийн хувьд ялгаатай олон субьекттэй харилцдаг. Иймэрхүү ялгаанууд нь хилийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахад олон төрлийн эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хилийн хяналтын байгууллагууд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд хяналт тавьж

ажиллана. Эдгээр хяналтыг дараах зурагт бүлэглэн авч үзлээ.

Дээрх чиглэлд тавих хяналт шалгалтын үйл ажиллагаа нь хэд хэдэн байгууллагын чиг үүрэгт хамаарна. Хэдийгээр хяналтын чиг үүрэг нь ангилал тус бүрт ялгаатай боловч боомтын хяналтын үйл ажиллагаа нь харилцан уялдаатай хэрэгжих тул орчин үед хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байна.

Хамтын ажиллагаа байнгын байх ёстой ба байгууллага хооронд харилцан ойлголцлын санамж байгуулах замаар үүнийг хэрэгжүүлдэг олон улсын туршлага байна. Гэхдээ байгууллага хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, тэдний ажлын давхардлыг арилгахад улс төрийн болон хууль зүйн зохицуулалт маш чухал болох нь уг асуудлыг цогц байдлаар нь шийдсэн олон орны туршлагаас харагдаж байна.

Ингэж байж хилийн хяналтын байгууллага бүр өөрийн эрхэм зорилт, үүрэг хариуцлага, ажил үүргийн хуваарийг эргэн харж, шаардагдах засварыг оруулах, бусад

байгууллагатай давхацсан ажил үүргээ шилжүүлэх, давхардлыг арилгах, байгууллагынхаа эрх ашгаас дээгүүр улс орны эрх ашиг, ард олны хүсэл эрмэлзлийг тавьснаар үүнийг биелүүлж чадна.

Улс орныг хөгжүүлэх, гадаад худалдааг идэвхижүүлэх “хаалга” болсон хилийн боомтуудад олон улсын стандарт, шаардлагад нийцсэн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэвтрүүлэх, суурилуулах, сайжруулах, тэдгээрийн болон боомтын барилга, байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах боомтын ашиглалтын захиргааны байгууллагыг хоёр хөрш орны адил бий болгож, Засгийн газрын харьяа агентлагийн түвшинд байхаар эрх зүйн зохицуулалт хийх;

Хилийн хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийн үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын хилийн боомтод ажиллаж амьдрах нөхцөлийг дээшлүүлэх, тэдэнд адил тэгш хөдөлмөрийн цалин хөлс, нийгмийн хамгааллын баталгаагаар хангах нэгдсэн бодлого чиглэлийг дээрх болон бусад холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах;

Хилийн хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийн үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын хилийн боомтод ажиллаж амьдрах нөхцөлийг дээшлүүлэх, тэдэнд адил тэгш хөдөлмөрийн цалин хөлс, нийгмийн

хамгааллын баталгаагаар хангах нэгдсэн бодлого чиглэлийг холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах;

Хилийн боомтод ажиллагсадын нийгмийн асуудал шийдэгдээгүй маш ихээр хаягдсан байна. Мэдээж тэдний гэр бүлийнхэн мөн адил энэ асуудалд хамаардаг. Сургууль нь хол, цэцэрлэг байхгүй, сургууль завсардах асуудал ихээхэн гардаг байна. Хилийн хяналт, шалгалтын байгууллагын ажиллах нөхцөл, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа ямар нэгэн байдлаар хангагдаагүй байна. Энэ асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх талаар хилийн тухай хууль болон бусад холбогдох хуулиадад тодорхой заалтуудыг нэмж оруулах;

Сүүлийн үед харьцангуй хөгжилтэй улс орнууд өндөр техник технологи дээр тулгуурлан бичиг баримтын нууцлалыг нарийвчлан шалгах, бичиг баримтанд тухайн эзэмшигчийн тодорхой мэдээллийг агуулсан чипийг байрлуулж, улсын хилээр нэвтрэх үед нь мэдээллийн нэгдсэн сүлжээнээс эзэмшигчийн баримт бичиг мөн эсэхийг батлах, тухайн хүнийг биометрийн багаж ашиглан нэмж тодотгох зэрэг шинэ хяналт шалгалтын арга ажиллагаанд аль хэдийн шилжин орсон байна. Иймд шинэ дэвшилтэд техник технологийг хилийн боомтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага гарч байгаа учир төрийн нэгдсэн бодлогын хүрээнд зохицуулалт хийж өгөх. Өнөөдрийн байдлаар улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэх, хяналт шалгалт хийх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх программ хангамжийн шинэчлэлийг гадаадын олон улсын байгууллагын төсөлт ажлаар хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь

өөрөө бусдаас хараат болох нөхцөл боломжийг бүрдүүлж байна гэж үзэж байна. Харин энэ байдлыг халж, өөрийн дотоод нөөц боломжийг түлхүү ашиглах явдал дутагдаж байгаад анхаарах;

Хилийн боомтыг дагалдан бий болох хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боомт бүрээр шинэчлэн боловсруулж, түүнд инженерийн дэд бүтцэд орох ус, цахилгаан, дулааны хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол зам, холбоожуулалтын талаар тусгах зэрэг асуудлуудыг бодлогын түвшин холбогдох мэргэжлийн байгууллага, яам агентлагийн дэмжлэг оролцоотойгоор цогц байдлаар шийдвэрлэсэнээр хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцолын түвшин үлэмж хэмжээгээр нэмэгдэж хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал эрс нэмэгдэх зэрэг эерэг үр дүн гарна.

### ДҮГНЭЛТ

Хилийн хяналтын байгууллагууд илүү уялдаа холбоотой байж, хяналт шалгалтыг давхардуулахгүй байх, ачаа барааг саатуулахгүй, бусад байгууллагын хяналт шалгалтын үр дүнг хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан, олон улсын конвенц, хоёр улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн хилийн боомтын талаарх Монгол Улсын хууль тогтоомжийг батлан гаргах, энэ талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлон, түүнийгээ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд суулгах; Хилийн хяналт шалгалтын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлохдоо

Монгол Улсын үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах, бүс нутгийн онцлогт тохируулан хилийн боомтуудыг гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, экспорт, импортыг дэмжих, хил залгаа улстай эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан улс орны хөгжлийг түргэтгэх, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг түргэн шуурхай байдлаар улсын хилээр нэвтрүүлэх нөхцөл бололцоог хангахад чиглүүлэх; Хилийн боомтод хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байгаа хилийн шалган нэвтрүүлэх алба, гааль, болон гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн байгууллагуудын чиг үүрэг, хамтран ажиллах журмыг энэхүү хуулиар зохицуулах;

- Хилийн хяналтын байгууллагуудын харилцан ажиллагааг улс төр –эрх зүйн, эдийн засгийн, олон улсын, технологийн, мэдээллийн гэх орчинд уялдуулан зохицуулах улс төрийн шийдвэр үгүйлэгдэж байна.

Орчин үеийн олон улсын худалдаанд худалдааг хөнгөвчлөх нь амин чухал асуудал болж хувирсантай холбоотойгоор эрсдэл тооцох арга зүйд суурилсан хилийн хяналт давамгайлах хандлагатай болсон нь дэлхийн улс орнуудын туршлагаар нотлогдож байна. Улсын хилээр нэвтэрч буй зорчигч, бараа, тээврийн хэрэгсэл бүрийн хууль зөрчих магадлалыг нь тооцож, зөвхөн зөрчил гаргах өндөр магадлал бүхий эрсдэлтэй объектуудыг онилсон, оновчтой, ухаалаг хяналтыг хэрэгжүүлэх нь хилийн хяналтын байгууллагуудын өмнө тавигдаж буй үндсэн зорилт боллоо.

Орчин үеийн техник, технологи, тооцоолон бодох арга зүй ба мэдээллийн системд гарч буй ахиц дэвшил, үүсэн бий болж буй

удирдлагын шинэлэг арга барилууд, хувь хүний чадавхид гарч буй өөрчлөлт зэрэг нь байгаа зөв онилсон хяналтыг хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Улмаар эрсдэл өндөртэй зорчигч, барааг

онилох замаар хилийн хяналтыг хялбаршуулах боломжийг олгож гадаад худалдааны бараа эргэлтийг хурдасган, улсын хилээр нэвтрэх зорчигчийг түргэн, шуурхай нэвтрүүлэх боломжийг олгоно.